Syndicated articles from

FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Сингапурын тэргүүн ах дүүсийн дайсагнал

Ли Куан Югийн хүүхдүүдийн дайсагнал ил болсон нь Сингапурт ховор тохиолдох үзэгдэл. > 10

Хятадын ДНБ-ий өсөлтийн төлөв сайжирлаа

Өсөлт тогтвортой ч Хятад улс эдийн засгийн шинэчлэлээ эрчимжүүлэх шаардлагатай. > 10

Марави дахь АНУ-ын цэргийн зөвлөхүүд

Маравид АНУ-ын цэргүүд байрлаж буй мэдээлэл Дутертег хүнд байдалд оруулав. > 10

The New York Times©

ОХУ-ын эсрэг хоригийг чангатгахыг дэмжлээ

Деметри Севастопуло, Кетрин Хилл

Москва АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд хөндлөнгөөс оролцоход дэмжлэг үзүүлсэн гэх үндэслэлээр Нэгдсэн улсын Сенат Оросын эсрэг хоригийг чангатгахыг дэмжив. Ингэснээр Оросыг залхаан цээрлүүлэх арга хэмжээг суллах Цагаан ордны боломж улам бүрхэг болж байна.

Ираны цөмийн баяжуулалтын эсрэг тавьж байсан хоригоо ОХУ-д зориулан нэмэлт өөрчлөлт оруулсныг нь Сенат 97:2 харьцаагаар дэмжсэн. Энэ нь Цагаан ордон, Кремльд хүчтэй дохио боллоо. Сенатад суудлын ялгаа тун багатай хоёр намын эл алхам 2016 оны Ерөнхийлөгчийн сонгуульд ОХУ кибер халдлага хийсэн явдалтай эвлэрч чадахгүй байгааг харуулж буй юм.

Бүгд найрамдах намаас Аризонаг төлөөлөн Сенатад сонгогдсон Жон МакКайн "Орос хөрш орнуудын дотоод үйл хэрэгт оролцож, АНУ-ын холбоотнуудыг заналхийлж, кибр халдлага хийхийг санаархсан болон өчүүхэн бага үр дагавартай байсан ч бусад улс орны сонгуульд хөндлөнгөөс оролцож буйг нь Владимир Путинд сануулаад дэндүү удаж байна" гэжээ.

Сенатын дэмжсэн хоригийг Төлөөлөгчдийн танхим батлах учиртай. Ингэснээр Цагаан ордон Холбооны мөрдөх товчооны хатуу хяналтад орох юм. Ийм арга замаар Дональд Трампын сонгуулийн гол дэмжигчид, Оросын хоорондох болзошгүй хуйвалдаанаас сэргийлнэ гэж үзэв.

Кибр халдлагын хариу болгож Оросын эсрэг арга хэмжээ авахыг Дональд Трамп дэмжээгүй нь Бүгд найрамдах болон Ардчилсан намынхныг байж суух газаргүй болтол бухимдуулжээ. Оросын Засгийн газар халдлага үйлдсэн гэдэг ямар ч мэдээллийг Кремль няцааж буй. Энэ оны эхээр АНУ-ын хуульчид Сирийн асуудал зэрэг тодорхой хүрээнд хамтын ажиллагаагаа идэвхжүүлж, харилцаагаа сайжруулахаар Оросын эсрэг хоригийг Дональд Трамп суллаж магадгүй хэмээн үзсэн билээ.

Түүнчлэн Барак Обама Ерөнхийлөгчийн үед Оросын эсрэг авч байсан хоригийг ч Сенат хуульчлах юм байна. Мөн хориг суллах, цуцлах аливаа хүчин чармайлтаа заавал Конгресстой зөвлөх ёстой гэдгийг Цагаан ордонд тулгажээ.

Цагаан ордон аливаа хоригийн эсрэг албан ёсны байр суурь баримтлахгүй. Гэхдээ Төрийн нарийн бичгийн дарга Рекс Тиллерсон энэ талаар бодолцож буйгаа битүүгээр илэрхийлжээ. Тэрбээр "Шаардлагатай үед бид уян хатан байх талаар асууна. Гэхдээ бүтцийн хувьд өөрчлөлт оруулах яриа хэлэлцээ хийх эрх бидэнд бий" хэмээн мягмар гарагт Конгрессын өмнө мэдэгджээ.

CSIS дэх Оросын шинжээч Хитер Конли "Ерөнхийлөгч хэн ч байсан Конгресст ингэж дөнгөлүүлэхдээ дуртай байхгүй. Оросын асуудал үнэхээр энгийн бус" гэж тэмдэглэв. Тэрбээр "Бид Оросын тагнуулын асуудлаар туйлын онцгой нөхцөл байдалд орчихоод байна. АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд хөндлөнгөөс оролцсон Оросын үйлдэлд Д.Трампын засаг захиргаа олигтой үйлдэл хийж чадахгүй" гэв.

Хориг албан ёсоор хэрэгжиж эхэлбэл ноён Трампын засаг захиргаатай харилцаагаа сайжруулах боломж алдагдах вий гэдэгт Москвагийн түгшүүр улам нэмэгдэх юм.

Засгийн газрын дэргэдэх тинк танк болох Оросын олон улсын асуудлаарх зөвлөлийн тэргүүн Андрей Кортунов "Дональд Трампын Оростой харилцаагаа сайжруулахаар хийх ямар ч алхам Вашингтоны байр суурь бухны өөдөөс улаан даавуу барьж буйгаас ялгаагүй үйлдэл гэдэг нь хэнд ч илэрхий байна" хэмээн тайлбарлалаа.

ОХУ-ын парламентын дээд танхим дахь олон улсын харилцаа эрхэлсэн хорооны дарга Константин Косачев АНУ-ын Сенатын алхмыг "оновчгүй" хэмээн тодорхойсныг Оросын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд цацаж байна.

Ерөнхийлөгч асан Барак Обама сонгуульд хөндлөнгөөс нөлөөлж болзошгүй хэмээн болгоомжилж, ОХУ-ын дипломат алхамд хаалт хийж, 35 дипломатчийг нь албадан гаргасан ч Кремль өнөөг хүртэл тэсвэртэй хандаж буй. Цагаан ордны Үндэсний аюулгүй байдлын зөвлөхөөр ажиллаж байсан, одоо бол Холбооны мөрдөх товчооны хяналтын төвд байгаа Майкл Флинн Трампын багийн байр суурь зөөлрөх хүртэл бага багаар хариу арга хэмжээ авахыг Москвагаас шаардсан удаатай.

Москва Трампын засаг захиргаатай нааштай харилцана гэж найдаж байсан. Гэвч нөхцөл байдал эргэж, Холбооны мөрдөх товчооны хяналтаас болоод, Оросын талаарх ноён Трампын аливаа үйлдэл хатуу эсэргүүцэлтэй тулгарч буй. Ноён Трамп Дугуй танхимдаа Оросын Гадаад хэргийн сайд Сергей Лавровтой хийсэн хувийн уулзалтын үеэр Холбооны мөрдөх товчооны дарга асан Жеймс Коми бол "галзуу нөхөр" байсан бөгөөд ажлаа өгснөөр Засаг захиргаанд нь ирэх дарамт багассан гэдгийг илэрхийлж хууль тогтоогчдоо цочролд оруулсан.

Иллинойсоос сонгогдсон Ардчилсан намын сенатч Тами Дакуорт "Сенатын шийдвэр бол Трампын Засаг захиргаанд Орос бидний нөхөр биш гэдгийг ойлгуулсан үйлдэл. Мөн Трамп чаддаггүй юм бол гаднын ямар ч заналт хүчнээс өөрийн улсын ардчиллыг хамгаалахад бэлэн байгаагаа Сенат илэрхийлж буй" хэмээв.

Обамагийн үеэс үйлчилсэн хоригийг АНУ цуцлахгүй байгааг Москва өнгөрсөн хугацаанд олон удаа сануулж, хэлж байсан. Гэвч Нэгдсэн улсын Сенатын сүүлийн алхам Москвагийн цухал дээр гал нэмлээ. Конгресс хоригийг байнгын болгож мэдэн гэдгийг Трамп үүрэгт ажлаа авснаас хойш Кремлийн албаны хүмүүс анхааруулсан. Түүнчлэн ОХУ хориг цуцлах, суллах эсэхэд тээсэн найдвараа үе үе суллаж, Трампын баг Оростой дэндүү ойр харьцах аваас АНУ-ын хууль тогтоогчид 1974 онд коммунист орнуудын эсрэг тавьж байсан Жексон-Веникийн нэмэлт өөрчлөлт шиг арга хэмжээ авч магадгүйг сануулж байсан түүхтэй.

FT

Гренфелл галын аюулгүй байдлыг хангаагүй байсан уу

Эдвин Хиткот

Цонхноос нь гал дүрэлзэж, Лондон даяар гүн хар утаа олгойдуулж буй Гренфеллийн цамхагт амь үрэгдэгсдийн тоо нэмэгдэж байгаа нь хотын сүүлчийн хар дарсан зүүд болоод байна.

Хойд Кенингстон дахь Lancaster West Estate-ийн дөрвөн цамхгийн нэг Гренфеллийг 1974 онд барьжээ. Уг цамхаг Кенингстон, Челсигийн хамтарсан, бага орлоготой иргэдийг орон сууцаар хангах төлөвлөгөөний нэг хэсэг байв. Харин энэ удаагийн хэрэг явдал Их Британи дахь орон сууцны өндөр барилгын хөөсрөлийг эцэс болгож мэдэх юм.

Бетонон уг цамхагт болсон хэд хэдэн эмгэнэлт явдалтай холбоотойгоор 1960-1970-аад онд угаасаа аюултай барилга гэх хошигнол хүртэл гарч байв. Гэсэн ч хямд бөгөөд 1968 онд дуулиантай нурж унасан Ronan Point цамхагтай ижил бүтэцтэй барьсан уг байгууламж гадна талдаа газар дээр нь шууд цутгасан бетон бүхий нүсэр барилга юм.

Цаг хугацаа яаж таарсан гэхээрээ уг барилга Лондоны зөвлөлийн архитекторуудын хэлтсийн төлөвлөлтийн гадна үлдсэн гэдгийг мэдэхгүй юм. Харин харьцангуй туршлага багатай Clifford Weardon түүний холбоотнуудын бүтээл аж. Гренфелл цамхагийг 1964 оноос барьж эхэлсэн түүхтэй.

Цамхагт сүүлийн жилүүдэд их засвар хийх ажлыг Studio E болон түүний гэрээлэгч Rydon констракшн гүйцэтгэсэн байна. Засвар өнгөрсөн жил дуусаж, байшингийн доод давхарт шинэ байгууламж барьж, цонх гаргаж, гадна фасадыг нь өнгөлгөөний хөнгөн цагаан хавтангаар хийжээ.

Оршин суугчдын хэлж буйгаар лхагва гарагийн өглөө гадна талаар нь хуягласан фасаднаас нь гал алдсан аж. Ослыг харж байсан нэгэн эх сурвалж "Яг л шүдэнз зурах мэт түргэн хугацаанд гал авалцсан. Амархан шатдаг материалтай" гэж тодотгожээ.

Өдрийн эхний хагас болоогүй байхад гал дээш авалцан, цамхагийн гадна тал хав хар болсон нь дүрс бичлэгээс тодорхой харагдаж байв. Гал гарсны дараа цамхагийн ойр орчим бөөн хар хогоор дүүрч, оршин суугчид тэдгээр хогийг сүүлд шинээр барьсан гадна талын хуягт өнгөлгөөний үлдэгдэл гэцгээж байв.

Өнгөлгөөний хавтангууд гал дээш огцом ноцох шалтгаан болсон юм бол эмгэнэлт явдалд хариуцлага хүлээх нэг зүйл нь энэхүү "гоёл" гэдэг нь тодорхой. Хөгийн санагдаж мэдэх ч ойролцоох Эрно Голдфингерийн загварыг нь гаргасан Треллик цамхаг Гренфеллээс хоёр жилийн өмнө баригдсан юм.

Хөнгөн цагаан хуягт өнгөлгөө гал хүчтэй авалцахад хүргэсэн анхны тохиолдол энэ удаагийнх биш юм. 2015 оны Зул сараар Дубай дахь 63 давхар Address цамхаг ч дүрэлзсээр байгаад дуусан. Хөнгөн цагааны орцтой өнгөлгөөний хавтан гал авалцуулсан тохиолдол мөн 2010 онд Шанхайд болсон. 24 давхар байшингийн өнгөлгөөний хавтангаас ноцсон гал 58 хүний аминд хүрч байжээ.

Нөгөөтэйгүүр, Гренфелл цамхаг шатсан явдал умард Кенсингтонд нягтрал хэчнээн их болсныг илтгэнэ. Бүхэл бүтэн 120 айлтай байшинд ганцхан шат байдаг нь гайхмаар. Мөн их засвар хийхдээ цамхагийн доод хэсэгт дахин орон сууц, үйлчилгээний төв барьжээ. Өргөтгөлийнх нь суурийг бетонон хөндлөвч дээр босгосон байна. Анхны эх сурвалжийн хэлж буйгаар оршин суугчдын хэн нь ч галын аюулын дохио сонсоогүй аж. Тэгэхээр гал унтраах шүршигч байдаг, эсэх нь эргэлзээтэй. Байлаа гэхэд ажилладаг, эсэх нь мөн тодорхойгүй байна.

Цамхагт их засвар хийх үеийн төлөвлөгөөг харахад зарим орон сууцанд галын гарцын зураг байхгүй байсан ба ердийн давхрууд дахь орон сууцнуудаас ч эрсдэлтэй харагдаж байгаа нь олон байлаа. Мөн анхны төлөвлөлтөөр ч коридорт гал унтраах систем байгаагүй байна. Тийм байтал ямар төлөвлөгөөг үндэслэж зөвшөөрөл олгодог вэ гэсэн асуултыг Гренфеллийн хэрэг явдал дагуулав.

FT

Австрали 70 сая долларын нөхөн олговор өгнө

Жейми Смит

Австралийн Засгийн газрын хэлэлцэгчид Папуа Шинэ Гвинейн Манус арал дээрх хуаранд зүй бус үйлдлийн бай болсон гэгдэх 1900 дүрвэгч, орогнол хүсэгчид 70 сая австрали долларын нөхөн олговор олгохоор болжээ.

Австрали руу орогнол хүсэхээр завиар их далайд гарсан боловч Номхон далайн өмнөд аралд хүрсэн дүрвэгчдийн өмнөөс зарга мэдүүлсэн хүний эрхийн хуульчид лхагва гарагт ийнхүү нөхөн төлбөр тооцуулахаар болж чадлаа.

Канберра уг шийдвэрийг хуулийн хүрээнд биш гэж үзэж буй ч олон нийтийн дунд сөрөг ойлголт төрүүлэхээс болгоомжилж, шүүх шийдвэр учраас биелүүлэхээр болжээ. Хуульчдын хэлж буйгаа эл шийдвэр өнөөдрийг хүртэл Австралид хүний эрхтэй холбоотой гарч байсан хамгийн сонгодог ялалт хэмээн тодорхойлжээ.

Эрхээ хамгаалуулж буй хүмүүсийн бие төлөөлөгч болох Slater & Gordon хуулийн фирмийн хуульч Эндрью Бейкэр "Шүүхийн шийдвэр Манус арал дээр баригдсан хүмүүс ямар дайсагнасан нөхцөл байдлыг даван туулсныг ойлгоход нэг алхам урагшилсан явдал боллоо" хэмээжээ.

Австралийн цагдаа нар дүрвэгч сууж явсан завийг эргүүлж, олон улсын усан нутаг дэвсгэрт оруулсан нь Өмнөд Номхон далайн арлуудад завиар ирсэн хүмүүсийг баривчлахад хүргэжээ. Үүний зэрэгцээ хууль бусаар ирсэн хэмээн үзэж, дүрвэгчийн статус олгохоос татгалзсан юм.

Гэвч энэхүү хатуу чиг шугам бүхий бодлогыг НҮБ болон хүний эрхийн төлөө тэмцэгчид хүчтэй шүүмжилсэн билээ. Австрали Манус арлыг аравдугаар сард буюу АНУ-тай дүрвэгчдийн хэлэлцээрээ дахин нягталсны дараа хаахаар төлөвлөөд буй. Харин Науру арал дээрх хуаранг нээлттэй үлдээх аж.

Папуа Шинэ Гвинейд дүрвэгчдийг илгээх болсноос дөрвөн жилийн дараа хууль зүйн хувьд асуудалтай дүрвэгч, орогночид Манус арал дээр үлдэж, тун хэцүү нөхцөлд амьдарч байсан юм. Нэгэн эрэгтэй тэнд 2014 онд гарсан мөргөлдөөний үеэр зодуулан амь эрсэдсэн бол хоёрынх нь эрүүл мэнд баривчилгааг дийлж чадаагүй юм. Түүнчлэн олон зуун хүн сэтгэл зүйн хувьд хүнд үеийг туулж буй.

Болсон явдалтай холбогдуулан зарга мэдүүлсэн Мажид Карами Камасае Засгийн газар болон түүний хэлэлцэгчдийн эл үйлдлийг бусдыг дорд үзсэн, зэрлэг балмад хэмээн тодорхойлсон юм. Тэрбээр хуульчийнхаа уншиж танилцуулсан мэдэгдэлд "Би Австралид ирээд энх тайван хайж ирсэн. Харамсалтай нь намайг Манус хэмээх тамд хүргэсэн" хэмээн дурджээ.

Мөн "Энэ хэрэг зөвхөн миний асуудал биш. Харин Манул арал дээр занганд орсон хүн бүрийн тухай асуудал. Бидний дуу хоолой хэзээ ч хүрдэггүй. Гэхдээ бид өнөөдөр сонсгож чадлаа" гэж бичжээ.

Австралийн цагаачлалын асуудал хариуцсан сайд Петр Даттон харин сөрөг хүчин болох Хөдөлмөрийн намыг эрх барьж байх хугацаандаа улсын хилийн хяналтыг алдсан хэмээн буруутгасан байна. Тэрбээр дүрвэгчдийг хүлээж авах бодлогын зардал 13.7 тэрбум австрали долларт хүрснийг хэлэв. Гэхдээ тэрбээр дүрвэгч суурьшуулахад гардаг Засгийн газрын төлөөлөгч, хэрэглээ болон аюулгүй байдлын зардлуудыг хэлээгүй юм.

Перт Даттон "Зургаан сар үргэлжилсэн энэ заргын дараа урьдчилсан байдлаар зөвхөн төлбөр нь хэдэн арван сая долларaар хэмжигдэж байна" хэмээжээ.

FT

Syndicated articles from

FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Ли Сянь Ян

Ерөнхий сайд Ли Сянь Лун

Отгон дүү Ли Вэй Лин

Сингапурын тэргүүн ах, дүүсийн дайсагнал

Живан Васагир

Сингапурыг үндэслэгч Ли Куан Югийн гурван хүүгийн дундах нь болох Ли Сянь Ян ойрын үед эх орноо орхин гадаадад гарах гэж байгаагаа мэдэгдлээ. Тэрбээр өөрийн ах, Сингапурын Ерөнхий сайд Ли Сянь Луны удирдлагад итгэл алдарсан тухайгаа саяхан отгон дүү эмэгтэйн хамт өгүүлж байжээ.

Эцэг нь 2015 онд нас барснаас хойш өөрийнх нь төдийгүй эхнэр, мөн дүү Ли Вэй Лин-ий эсрэг төрийн аппаратыг ашиглаж болзошгүй нөхцөл үүссэнд эмээж байгаагаа Ли Сянь Ян Сингапурын олон нийтэд хандсан ердийн бус мэдэгдэлдээ тайлбарлав.

Ууган хүү болох Ли Сянь Лунг эрх мэдэлдээ дулдуйдан, эдүгээ Сингапурын Засгийн газрын агентлагт зөвлөх хийж буй хүү Ли Хун Иг залгамжлагчаа болгохоор бэлтгэж байна хэмээн дунд ах, дүү хоёр зэмлэв.

Үг хэлэх эрх чөлөөг сүртэй нь аргагүй хянадаг хот-улсад тэргүүн ах дүүсийн дайсагнал олонд ил болсон нь ховор тохиолдох үзэгдэл. Дээрх мэдэгдэл нь Сингапурын өнөөгийн улс төрийн эрх мэдлийн үнэн төрхийг харуулж өглөө. Сингапурын анхны удирдагчийн ууган хүү Ли Сянь Лун эдүгээ тус улсын Ерөнхий сайд, харин эхнэр Хо Чин нь төрийн хөрөнгө оруулалтын Temasek компанийн ерөнхий захирал.

Мэдэгдэлд хариу болгон Сингапурын Ерөнхий сайд Facebook-т "Дүү нарын маань зэмлэл намайг тун гутраалаа. Хо Чин бид хоёр энэ бүх зэмлэлийг эрс няцааж байна. Ялангуяа, хүүгээ улс төрийн залгамжлагч болгох гэж байгаа гэсэн шүүмж ор үндэсгүй" хэмээн бичжээ.

Эцгийгээ таалал төгссөний нэг жилийн ойтой холбогдуулан улс төрийн эрх мэдлээ буруугаар ашигласан хэмээн Ерөнхий сайдын отгон дүү өнгөрсөн жил ууган ахаа буруутгаснаар ах дүүсийн хоорондох дайсагнал анх илэрсэн юм. Ах нь төрийн эрх мэдлийг хувийн эрх ашгийнхаа төлөө ашиглаж байна хэмээн хоёр дүү нь лхагва гарагт мэдэгдсэнээр дайсагнал гаарлаа.

Эцгийнх нь амьдарч байсан байшин ч ах дүүсийн хэрүүлийн бас нэг шалтаг болох гэж байна. Сингапурыг үндэслэгч эцэг нь Орчард дүүрэгт гурван хүүхдээ өсгөж, хүн болгосон байшингаа нас бармагц нураагаарай хэмээн гэрээслэсэн ажээ. Харин том ах нь дүү нартайгаа санал зөрж, байшинг дурсгал болгон үлдээхээр шийдсэн аж.

"Эцгийг амьд сэрүүн байхад л байшингаа нураагаарай гэсэн гэрээсийг нь Сянь Лун эхнэр Хо Чиний хамт эсэргүүцэж байсан" хэмээн хоёр дүү нь мэдэгдлээ.

"Сянь Луны улс төрийн эрх мэдэл нь Сингапурыг үндэслэгчийн хүү болдогтой нь уялдаатай. Эрх мэдлээ цаашид ч залгамжлуулах зорилгоор Ли Куан Югийн байшинг үлдээх гээд байгаа хэрэг" хэмээн уг мэдэгдэлд тайлбарласан байна.

"Би оршин буй тогтолцоог эсэргүүцдэг, сөрөг хүчин биш. Төрийн албанд олон жил зүтгэсэн намтартай хүн. Энэ улсыг орхих гэж байгаадаа зүрх минь өвдөж байна. Бодитой шалтгаан байгаагүйсэн бол ийм юм хийхгүй байлаа" хэмээн Сингапурын иргэний агаарын албаны тэргүүн, урьд нь тус улсын харилцаа холбооны Singtel компанийн ерөнхий захирлаар ажиллаж байсан ноён Ли Financial Times-т өгүүлсэн юм.

Эх орноо яг хэзээ орхих гэж буйгаа хараахан шийдээгүй талаар ноён Ли Сянь Ян нэмж тайлбарлав. Түүний эхнэр Ли Сют-Ферн компанийн хуульч мэргэжилтэй.

Ерөнхий сайд Ли Сянь Лун "Дүү нарынхаа өмнө зөв болохоо харуулахын тулд чадах бүхнээ хийнэ. Цаашид ч Сингапур улсад үнэнч шударга зүтгэж, байдаг бүхнээ зориулах болно. Ялангуяа, манай нийгмийн суурь зарчим - авьяас чадвараар нь үнэлэх тогтолцоог хадгалж явна" хэмээн дүү нарынхаа мэдэгдэлд хариу тайлбар өглөө.

"Одоогоор миний бие эхнэрийн хамт хилийн чанадад байгааг дүү нар маань мэдэж байгаа. Энэ долоо хоногт эх орондоо харьсан хойно энэ хэргийг нухацтай хэлэлцэнэ" хэмээн Ерөнхий сайд бичжээ.

Колоничлолын дараах Зүүн өмнөд Азийн улсууд дотроо хөгжил дэвшлээр тэргүүлэгч болдогтоо авторитар Сингапур эртнээс бахархаж ирсэн юм. Ийм ч учраас шинжээч нар Ли овогт ах дүүсийн зөрчлийг онцгой сонирхож байна. Ах дүү гурвын эцэг Ли Куан Ю нь стратегийн чухал байрлалд оршдог ядуу улсыг Азийн нарийн технологийн зангилаа болгон хувиргасан гавьяатан.

Ерөнхий сайдын хүү, 30 настай Ли Хун И нь Сингапурын Засгийн газрын тэтгэлгээр Массачусетсийн технологийн их сургуульд эдийн засаг, компьютерын ухаанаар суралцсан. Сингапурын зэвсэгт хүчинд салааны захирагчаар зургаан жил алба хаасан тэрбээр өвөг эцгийнхээ оршуулгын ёслол дээр уйлж, салах ёслолын үгийг нь хэлж байлаа. Чухам энэ нь сингапурчууд Ли Хун Иг ирээдүйн удирдагч хэмээн таамаглах шалтгаан болжээ.

"Сингапурын удирдлагыг атгаж буй ах дүүс дотроос, улс төр дундаас нь Ли овогтын гурав дахь үеийг анхаар гэсэн асуудал анх удаа гарч буй нь энэ" хэмээн Аделаид дахь Флиндерсийн их сургуулийн олон улсын харилцааны профессор Майкл Барр өгүүлэв.

Улс орны амьдралд профессионализм, төлөвлөлт, авлигад үл идэгдэх зарчмыг дээдэлдэг "Сингапур загвар"-тай холбоотой учраас ах дүүсийн зөрчил нь Ли овогтынхны нэр хүндийг хамгаалж үлдэхтэй холбоо бүхий чухал асуудал хэмээн ноён Барр тайлбарласан юм.

"Сингапур оронд Ли хэмээх брэндийг тусгаж явах нь үйлдвэрлэл болж хувирлаа. Гэхдээ энэ брэнд хамгаалалттай. Ерөнхий сайд өөрийнхөө замыг л хамгаалаад байгаа хэрэг. Брэндээ хамгаалахад нь аюул учруулж буй хүмүүс ердөө дүү нар нь".

FT

Марави дахь АНУ-ын цэргийн зөвлөхүүд

Майкл Пийл, Грэйс Рамос

Исламын зэвсэгт бүлэглэл булаан эзэлсэн Марави хотын ойролцоо АНУ-ын цэрэг байрлаж буй талаар Филиппиний армийнхан мэдэгдсэн нь тус улсын Засгийн газар гурван долоо хоногийн өмнө үүссэн хямралт байдлыг намжааж дийлэх нь үү гэсэн асуулт тавихад хүргэлээ.

Америкийн цэргүүд байлдааны бус үүрэг гүйцэтгэж буй талаар Филиппиний армийн дээд тушаалын офицер тайлбарлав. Зэвсэгт босогчид Марави хотын зарим хэсгийг эзлэхээс бүр өмнө, хэт даврагчдын болзошгүй ажиллагаанд бэлэн байх талаар Филиппиний цэргүүдэд анхааруулж байжээ.

Гэвч Зүүн өмнөд Ази дахь хэт даврагчдын сэргэлтийг дутуу үнэлснээс үүдэн, бүслэлтийн үеэр нийт 300 орчим зэвсэгт босогч, цэрэг, энгийн иргэн амь үрэгдсэн. Энэ нь Ерөнхийлөгчөөр сонгогдоод жил болж буй Родриго Дутертегийн нэр хүндэд занал учруулаа. Ноён Дутерте үндэсний аюулгүй байдлын эвлэршгүй хатуу бодлого баримтлагч гэсэн имижтэй ч Марави хот байрладаг төрөлх Минданао арал дээрээ энх тайван тогтоохоор чармайж байна.

Маравигийн ойролцоо байрлаж буй АНУ-ын цэргүүдийг байлдааны ажиллагаанд оролцохыг хориглосон талаар Филиппиний бригадын генерал Реституто Падилла мэдэгдэв. "Манай цэргүүдийн шаардлагатай мэдээллээр хангадаг төхөөрөмжийг ажиллуулах үүрэгтэй АНУ-ын зарим албан хаагч ажиллаж байгаа" талаар генерал өгүүлсэн. Гэхдээ АНУ-ын хэдэн цэрэг, ямар үүрэг гүйцэтгэж буй талаар тодорхой тайлбарласангүй.

Филиппиний цэргийнхнээс өгсөн мэдээллийн дагуу Манила дахь АНУ-ын Элчин сайдын яамнаас тайлбар хүссэн ч хариу өгсөнгүй. Гэхдээ исламист, коммунист босогчдын хөлд олон арван жилийн турш доргиж ирсэн Филиппиний өмнөд хэсэгт Засгийн газрын зэвсэгт хүчнийг сургаж, дадлагажуулах, зөвлөгөө өгөх, дэмжих үүрэгтэй тусгай баг илгээдгээ Вашингтон эрс багасгаад байгаа юм.

Маравигийн ойролцоо АНУ-ын цэргүүд байрлаж буй тухай мэдээлэл нь Филиппиний Ерөнхийлөгч Дутертег түвэгтэй байдалд оруулаа. Тэрбээр эрт цагийн колоничлогч, эдүгээ цагийн холбоотон АНУ-ыг Филиппинд "Нохой аятай хандлаа" хэмээн шүүмжилсэн удаатай. Марави дахь байлдааны ажиллагаанд АНУ-аас тусламж хүссэн зүйлгүй талаар ноён Дутерте тайлбарлав.

Байлдааны ажиллагаанаас шалтгаалан Марави хотын үндсэндээ ислам сүсэгт 200 мянган оршин суугчийн ихэнх нь дүрвэн зайлжээ. Мөн ISIS-ийн анхаарал Зүүн өмнөд Азид чиглэж буйтай уялдан бүс нутагт исламын экстремизм гаарна гэсэн айдас ихэслээ. Босогчдын удирдагчийг баривчлахаар тавдугаар сарын 23-нд амжилтгүй дайралт зохион байгуулснаас хойш Маравид дор хаяж 206 босогч, 58 цэрэг, 26 энгийн иргэн амь үрэгдсэн талаар Филиппиний армийн төлөөлөгч мэдэгдсэн.

ISIS-ийн хатгалгаар зоригжсон орон нутгийн зэвсэгт бүлэглэл Марави хотыг эзлэхээр бэлтгэж буй мэдээллийг тагнуулынхнаас тавдугаар сарын 18-нд хүлээн авсан талаар Филиппиний эрх баригчид тайлбарлав. Зэвсэгт бүлэглэлийн дайралтын дараа ноён Дутерте ОХУ-д хийж байсан айлчлалаа шууд зогсоож, Филиппиний өмнөд хагаст байлдааны цагийн байдал зарлажээ.

FT

Хятадын ДНБ-ий өсөлтийн төлөв сайжирлаа

Юань Ян

Өсөлт тогтвортой ч Хятад улс эдийн засгийн шинэчлэлээ эрчимжүүлэх шаардлагатай талаар Олон улсын валютын сангаас (ОУВС) жил тутам нийтэлдэг тайланд анхааруулжээ.

"Дунд хугацааны тогтвортой өсөлтийг хангаж, эрс өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийг багасгах гэвэл шинэчлэлийн явцыг хурдасгах шаардлагатай" хэмээн ОУВС-гаас лхагва гарагт гаргасан, БНХАУ-ын эдийн засгийн талаарх IV тайланд тайлбарласан байна. Гэхдээ санхүү, орон сууцны зах зээлд хатуу бодлого баримталсны дүнд богино хугацааны зарим эрсдэл арилсан болохыг ОУВС хүлээн зөвшөөрлөө.

Хятадын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг анх 6.6 хувиар тооцоолж байсан ОУВС 6.7 болгон өөрчиллөө. Мөн Хятадын Засгийн газрын тооцоотой нийцүүлэн, тус улсын ДНБ-ий 2018-2020 оны өсөлтийг 6.4 хувь болгон бууруулжээ.

"Гэхдээ Хятадын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах гэвэл өр зээлийн хөрөнгө оруулалтад түшиглэж буй одоогийн өсөлтийн загвараас шинэ загварт шилжих эрс шинэчлэл өрнүүлэх нь чухал" хэмээн ОУВС-ийн орлогч захирал Дэвид Липтон тайлбарлав.

Хятадын эдийн засгийн өсөлтийг үндсэндээ хөрөнгө оруулалтаар үүсгэж ирсэн. Гэтэл дэд бүтэц, үл хөдлөх хөрөнгөд оруулах хөрөнгө оруулалт багассанаас шалтгаалан уг өсөлт удааширчээ. Тавдугаар сарын байдлаар дэд бүтцэд оруулах хөрөнгө оруулалтын өсөлт 4.3, үл хөдлөх хөрөнгийн салбарт оруулах хөрөнгө оруулалт 2.3 хувиар унасан хэмээн лхагва гарагт БНХАУ-д нийтлэгдсэн албан ёсны статистик мэдээнд тайлбарлажээ. Энэ нь тавдугаар сард үндсэн хөрөнгөд оруулах хөрөнгө оруулалтын өсөлт жилийн өмнөх үетэй харьцуулахад 7.8 хувь болж удааширсан хэрэг юм.

Энэ онд санхүү, орон сууцны зах зээлд үнийн хөөс үүссэнтэй уялдан санхүүгийн эрсдэл үүсэж болзошгүй талаар Бээжин мэдэгдэж байв. Үүнтэй уялдан зохицуулах байгууллагууд хөрөнгийн зах зээл дэх үнэ өсгөх зорилготой явуулагыг хориглож, даатгалын компани, үл хөдлөх хөрөнгө хөгжүүлэгчийн үйл ажиллагааг хязгаарлах арга хэмжээ авсан.

"Шинэчлэл өрнүүлэхэд Хятад оронд хэр хугацаа хэрэгтэйг мэдэх хүн байхгүй. Гэхдээ арга хэмжээ авахгүй л бол хөрөнгө оруулалтаас орох ашиг буураад л байх болно" хэмээн Macquarie Capital-ийн Ларри Ху тайлбарлав.

Орон нутгийн засаг захиргаа том хотууд дахь орон сууцны эрэлт хэрэгцээг хязгаарлах зорилготой олон арга хэмжээ авсны үрээр үнэ буурч, борлуулалт хумигдаж байна. Үл хөдлөх хөрөнгө хөгжүүлэгчдийн санхүүжүүлэлтийн эх үүсвэрт хязгаар тогтоолоо.

"Санхүү, үл хөдлөх хөрөнгийн зах зээлд авч буй энэ бүх арга хэмжээ нь шинэчлэл бус, хязгаарлалт учраас богино хугацааны эрсдэлийг бууруулах төдий үүрэгтэй. Тэгэхээр урт хугацааны эрсдэл хэвээрээ байгаа хэрэг" хэмээн ноён Ху үзлээ.

Авлига, сэжигтэй хөрөнгө оруулалтыг нухчин дарсаар байгаа БНХАУ-ын Засгийн газар Anbang даатгалын компанийн захирал зэрэг дээд түвшний санхүүчдийг хараалахаас ч эмээхгүй байгаагаа харуулж саяхан баривчилсан. Уг арга хэмжээний дараа Хятадын даатгалын гол компаниудын зарим нь зах зээлд эрсдэлтэй

хөрөнгө гаргахаа зогсоов. Тус улсын банкуудын зохицуулах байгууллага Хятад оронд далд ажилладаг "сүүдрийн банкны үйлдвэрлэл"-ийг нухчин дарах зохицуулалтын шуурга дэгдээлээ.

Олон улсын өмнө хүлээсэн амлалтаа сахин биелүүлэх гэвэл Хятадын эдийн засгийн статистик үзүүлэлтийг ч итгэл төрөхүйц сайжруулах шаардлагатай талаар ОУВС анхааруулав. Бодит байдалд үл нийцэх хуурмаг засвар оруулсан Хятадын эдийн засгийн албан ёсны статистик нь гаднын хөрөнгө оруулагчдад чиг баримжаа болж чадахгүй байгааг олон улсын эдийн засагчид эртнээс шүүмжилж иржээ. Ялангуяа, Хятадын эдийн засгийн өсөлтийн хурдац, ажил эрхлэлтийн түвшинтэй холбоотой өгөгдөл сэжиг төрөм тогтвортой байдаг нь тус улсад нүүрлэсэн эдийн засгийн эрсдэлт нөхцөлийг бага тусгаж хэмээн хардах үндэс болдог.

Хятадын зүүн умардын Ляонин муж санхүүгийн статистикийг хуурамчаар гаргаснаа хүлээн зөвшөөрсний дараахан төвийн Засгийн газар дахиад хоёр мужийг эдийн засгийн хуурамч тооцоо хийсэн хэмээн энэ долоо хоногийн эхээр шүүмжилсэн юм.

FT